

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-148-ЫН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлт</p> <p align="center"><i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/18 хуудас/ 2017 оны NZ amend.5</i></p>	<p>АГААРЫН ХӨЛӨГТ ХАМААРАХ БҮТЭЭГДЭХҮҮН, ЭД АНГИ ҮЙЛДВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ</p> <p align="center"><i>(Хүчинтэй мөрдөгдөж байгаа)</i> <i>/ 11 хуудас (үндсэн дүрэм- 16 хуудастай байсан)/ 1997 оны NZ original</i></p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>БҮЛЭГ А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>148.1. Зорилго Энэ Дүрэм нь агаарын хөлөг, бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эд анги болон материал үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>148.1. Зорилго (а) Агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэгч байгууллага (цаашид ҮБ гэх)-ыг гэрчилгээжүүлэх, үйл ажиллагааных нь журмыг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p>
<p>148.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>148.3. Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>148.5. Гэрчилгээний шаардлага (а) Аливаа этгээд энэ дүрмийн дагуу олгосон үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээний нөхцөл болон эрхийн хүрээнээс гадуур, 148.11-д заасан эрхийг хэрэгжүүлэхгүй. (б) Энэ зүйлийн (а) нь сонирхогчийн бүтээсэн агаарын хөлөгт хамаарахгүй.</p>	<p>148.5. Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлагууд (а) Аливаа этгээд нь энэ дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшээгүй тохиолдолд 148.11-д заасан эрхийг эдлэхгүй. (б) Энэ зүйлийн (а) заалт нь сонирхогчийн угсарсан агаарын хөлөгт хамаарахгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>148.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24148/01 маягыг бөглөж дараах баримтын хамт Даргад ирүүлэх үүрэгтэй: (1) 148.67-д шаардсан, хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар; (2) хэрэв хамааралтай бол зохих төлбөрийн баримт.</p>	<p>148.7. Өргөдөл гаргах (а) Энэ дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч /цаашид Өргөдөл гаргагч гэх/ нь ИНЕГ-0148/01 маягыг бөглөж, ИНЕГ-аас шаардсан тохиолдолд нэмэлт тодруулга, мөн төлбөрийн баримтыг хавсарган ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>148.9. Гэрчилгээ олгох Хэрэв Дарга хүсэлт гаргагчийг дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг энэ Дүрмийн дагуу олгох үүрэгтэй: (1) хүсэлт гаргагч нь В Бүлгийн шаардлагыг хангасан; (2) хүсэлт гаргагч болон 148.51(а)-ийн дагуу шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх; (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>148.9. Гэрчилгээ олгох (а) ИНЕГ-аас дараах шаардлагуудыг хангасан өргөдөл гаргагчид ҮБ-ын гэрчилгээг олгоно: 1/ энэ дүрмийн Бүлэг Б-ийн шаардлагуудыг хангасан; 2/ ажилтан, албан тушаалтан нь 148.51-ын (а)–д заасан шаардлагуудыг хангасан; 3/ гэрчилгээг олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх нөхцөлийг хангасан. (б) ҮБ-ын гэрчилгээг, байгууллагын зааварт нь хэрхэн тодорхойлогдсоноос хамааран дараах ангиллаар олгоно: 1/ агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл агаарын хөлгийн сэнс үйлдвэрлэхээр тодорхойлогдсон бол M1;</p>	<p>-Amend.2-оор өөрчлөгдсөн -148.11(а) заалт</p>

	<p><u>2/ агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл агаарын хөлгийн сэнсний бүрэлдэхүүн хэсгүүдийг үйлдвэрлэхээр тодорхойлогдсон бол М2;</u> <u>3/ агаарын хөлөгт хамаарах хэрэглэл, эд ангиудыг үйлдвэрлэхээр тодорхойлогдсон бол М3;</u> <u>4/ агаарын хөлөгт ашиглах материалыг үйлдвэрлэхээр тодорхойлогдсон бол М4.</u></p>	байсан.
<p>148.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх (a) <u>Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээнд, тухайн гэрчилгээгээр олгосон, байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан дараах 1, эсхүл хэд хэдэн үйлдвэрлэлийн зэрэглэлийг заана:</u> (1) <u>М1- агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл сэнс үйлдвэрлэх;</u> (2) <u>М2- агаарын хөлгийн, агаарын хөлгийн хөдөлгүүрийн, эсхүл сэнсний бүрдэл хэсгийг үйлдвэрлэх;</u> (3) <u>М3- эд анги, эсхүл хэрэгсэл үйлдвэрлэх;</u> (4) <u>М4- материал үйлдвэрлэх.</u> (b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээнд заасан үйлдвэрлэлийн зэрэглэлийн дагуу эд зүйлийг үйлдвэрлэж болно. (c) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч үйлдвэрлэсэн эд зүйлдээ, тухайн эд зүйл нь холбогдох маягийн загвартаа нийцэж байгаа ба аюулгүй ажиллагааны нөхцөлд байгааг харуулсан САА Form One- шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээг олгож болно.</p>	<p>148.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх (a) Гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээнд заасан ангиллын хүрээнд агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд ангиудыг үйлдвэрлэнэ. (б) Гэрчилгээ эзэмшигч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ, тухайн бүтээгдэхүүн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, маягийн загварт нийцэж байгааг баталгаажуулсан гэрчилгээ (authorized release certificate)-г олгож болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.2- оор нэмэгдсэн</p>
<p>148.13. Гэрчилгээний хугацаа (a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл <u>сунгаж</u> болно. (b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл <u>түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй</u> болгосноос бусад тохиолдолд, хүчинтэй хэвээр байна. (c) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол, гэрчилгээг Даргад нэн даруй <u>хураалгана.</u> (d) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.</p>	<p>148.13. Гэрчилгээний <u>хүчинтэй</u> хугацаа (a) ҮБ-ын гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно. (б) ҮБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, эсхүл ИНЕГ-аас үйл ажиллагааг нь <u>түр болон бүрмөсөн</u> зогсоох хүртэл хүчин төгөлдөр байна. (в) ҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан буюу гэрчилгээг хүчингүйд тооцсон тохиолдолд гэрчилгээг ИНЕГ-т нэн даруй <u>хүргүүлнэ.</u> (г) ИНЕГ-аас ҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхийг түр хугацаагаар хязгаарласан тохиолдолд, гэрчилгээнд холбогдох тэмдэглэлийг хийлгэхээр ИНЕГ-т ирүүлнэ.</p>	-Орчуулга, найруулга зассан
<p>148.15. Үйлдвэрлэлийг зогсоох мэдэгдэл (a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний эрхийг хэрэгжүүлэхээ зогсоосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй. (b) Мэдэгдэл нь үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээг хүчингүй</p>	<p>148.15. Үйл ажиллагаагаа зогсоох (a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэх ажиллагаагаа зогсоохоос 30 хоногийн өмнө ИНЕГ-т мэдэгдэж, ҮБ-ын гэрчилгээг хүчингүйд тооцох тухай хүсэлтээ гаргасан байна.</p>	-Орчуулга, найруулга зассан

болгуулах хүсэлтийг багтаасан байх ёстой.		
<p>148.17. Гэрчилгээ <u>сунгах</u></p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ <u>сунгуулах хүсэлтийг</u> САА 24148/01 маягтаар гаргана.</p> <p>(b) Тухайн хүсэлтийг гэрчилгээнд заасан сунгах хугацаанд, хэрэв сунгах хугацааг гэрчилгээнд заагаагүй бол, гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.</p>	<p>148.17. Гэрчилгээг <u>шинэчлэх</u></p> <p>(a) ҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг <u>шинэчлэх тухай өргөдлийг</u> ИНЕГ-0148/01 маягтын дагуу гаргана.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан өргөдлийг, гэрчилгээнд заасан шинэчлэх хугацаанд, хэрэв гэрчилгээнд шинэчлэх хугацаа заагаагүй бол гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө ИНЕГ-т гаргана.</p>	<p>-Renewal –шинэчлэх гэснийг сунгах гэж өөрчилсөн. -Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>БҮЛЭГ Б. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД.</p>	
<p>148.51. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг <u>үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</u></p> <p>(1) тухайн байгууллагын бүх ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй <u>Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;</u></p> <p>(2) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд. Удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь дараах үйл ажиллагааны чиглэлээр <u>Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх үүрэгтэй:</u></p> <p>(i) хангамж;</p> <p>(ii) үйлдвэрлэл;</p> <p>(iii) үзлэг шалгалт болон тест;</p> <p>(iv) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;</p> <p>(3) Ерөнхий зааварт заасан үйлдвэрлэлийн ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны</p>	<p>148.51. Ажилтан, албан тушаалтанд тавигдах шаардлага</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:</p> <p>1/ гэрчилгээ эзэмшигчийн явуулж буй бүх үйл ажиллагаа энэ дүрэмд заасан стандарт шаардлагын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах эрхтэй <u>удирдах албан тушаалтан;</u></p> <p>2/ гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа энэ дүрмийн дагуу явагдаж буй эсэхийг хянах, зохицуулах үүрэг хүлээсэн удирдах ажилтнуудтай байх ба эдгээр ажилтан нь дараах чиглэлүүдээр <u>удирдах албан тушаалтны өмнө хариуцлага хүлээнэ:</u></p> <p>2.1 хангамж;</p> <p>2.2 үйлдвэрлэл;</p> <p>2.3 хяналт шалгалт ба сорилт туршилт;</p> <p>2.4 чанарын дотоод баталгаажилт.</p> <p>3/ гэрчилгээ эзэмшигчийн зааварт заасан үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, удирдах, хянах, баталгаажуулах /гэрчилгээжүүлэх/ үүрэг бүхий ажиллагсад.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-SMS-ийн шаардлага нэмэгдсэн</p>

<p>ажилтан.</p> <p><u>(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар туршлагаа нотлох үүрэгтэй.</u></p> <p>(b) <u>Хүсэлт гаргагч нь</u> дараах үүрэгтэй:</p> <p>(1) байгууллагын Ерөнхий зааварт заасан үйлдвэрлэлийн ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл гэрчилгээжүүлэх ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх түүнийг хадгалах журмыг тогтоох;</p> <p>(2) дээрх ажилтанд түүний эрхийн хүрээг бичгээр тодорхойлсон нотлох баримт олгох.</p>	<p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах үүрэгтэй:</p> <p>1/ өөрийн үйл ажиллагааны заавартаа тусгагдсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, үзлэг шалгалт хийх болон баталгаажуулах, гэрчилгээжүүлэхэд оролцох ажилтнуудын сургалтын болон ур чадварыг тогтоох журам боловсруулсан байна;</p> <p>2/ дээрх ажилтнуудын эрх, үүргийг бичгээр тодорхойлсон байна.</p>	<p>-Amend.5-аар нэмэгдсэн</p>
<p>148.53. <u>Байгууламжийн шаардлага</u></p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа үйлдвэрлэлийн бүх үйл ажиллагаанд тохирсон байгууламжтай байх үүрэгтэй.</p> <p>(b) <u>Энэ зүйлийн (а)-д шаардсан байгууламж нь дараах байгууламжаас бүрдсэн байх ёстой:</u></p> <p>(1) байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдах захиргааны байр;</p> <p>(2) үйлдвэрлэлийн <u>байгууламж</u>:</p> <p>(i) хэрэв хамааралтай бол цаг агаарын нөхцөлөөс хамгаалагдсан;</p> <p>(ii) тусгай ажлын байр нь хүрээлэн буй орчин болон ажлын байрны бохирдлоос сэргийлж тусгаарлагдсан;</p> <p>(3) үйлдвэрлэсэн эд зүйл төхөөрөмж болон багаж хэрэгсэл хадгалах дараах байгууламж:</p> <p>(i) ажиллагаатай эд зүйлийн аюулгүйн хамгаалалтыг хангасан;</p> <p>(ii) ажиллагаатай, ажиллагаагүй эд зүйлийг ангилан тусгаарласан;</p> <p>(iii) хадгалагдаж байгаа эд зүйл гэмтэх, элэгдэхээс сэргийлэх хяналттай;</p> <p>(4) орчин нөхцөл нь тухайн гүйцэтгэх ажилд тохирсон байх ба ялангуяа үйлдвэрлэлийн процессын тодорхойлолтод заасан, орчны тусгай шаардлагад нийцсэн байна.</p>	<p>148.55. <u>Ажлын байранд тавигдах шаардлага</u></p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ үйл ажиллагаагаа явуулах, хяналт тавих ажлын байртай байна;</p> <p>2/ үйлдвэрлэл <u>явуулах байр нь</u>:</p> <p>2.1 цаг агаарын тааламжгүй нөхцлөөс хамгаалагдсан;</p> <p>2.2 тусгай үйл ажиллагаа эрхлэх ажлын байр нь бохирдол бүхий бүс ба орчноос тусгаарлагдсан байна;</p> <p>3/ бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хадгалах агуулах, байр нь:</p> <p>3.1 ажиллагаатай эд ангиуд найдвартай хамгаалагдсан;</p> <p>3.2 ажиллагаатай болон ажиллагаагүй эд ангиуд тусгаарлагдсан;</p> <p>3.3 хадгалагдаж байгаа эд ангиудыг гэмтэх, чанараа алдахаас сэргийлэгдсэн байна.</p> <p>(б) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагаа явуулах орчин нь тухайн үйл ажиллагааны онцлогт тохирсон, туршилт явуулахад шаардлагатай тусгай нөхцөлийг хангасан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.2-оор нэмэгдсэн</p>

<p>148.55. Төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материал Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:</p> <p>(1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа үйлдвэрлэлийн бүх ажиллагаанд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материалыг бэлэн байлгана;</p> <p>(2) багаж хэрэгсэл, эталон (jigs), боловсруулалтын болон тестийн төхөөрөмжийн тохируулгыг багтаасан, төхөөрөмж, багаж хэрэгсэл болон материалын хяналтын журмыг тогтооно.</p>	<p>148.57. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь:</p> <p>1/ байгууллагын үйл ажиллагааг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон шаардлагатай материалаар хангагдсан байна;</p> <p>2/ тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалтай ажиллах болон өндөр нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журмыг боловсруулсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>148.57. Маягийн гэрчилгээ болон загварын зөвшөөрөл</p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үйлдвэрлэх бүтээгдэхүүний хувьд дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) ИНД-21-ийн В Бүлгийн дагуу тухайн бүтээгдэхүүнд олгосон маягийн гэрчилгээ эзэмшдэг, эсхүл эзэмших хүсэлт гаргасан байх; эсхүл</p> <p>(2) ИНД-21-ийн Е Бүлгийн дагуу тухайн бүтээгдэхүүнд олгосон нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшдэг, эсхүл эзэмших хүсэлт гаргасан байх; эсхүл</p> <p>(3) <u>дараах гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагчтай Даргын хүлээн зөвшөөрөхүйц зохицуулалт хийсэн байх:</u></p> <p>(i) <u>ИНД-21-ийн В Бүлгийн дагуу тухайн бүтээгдэхүүнд олгосон маягийн гэрчилгээ; эсхүл</u></p> <p>(ii) <u>ИНД-21-ийн Е Бүлгийн дагуу тухайн бүтээгдэхүүнд олгосон нэмэлт маягийн гэрчилгээ.</u></p> <p>(b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үйлдвэрлэх, бүтээгдэхүүн биш эд зүйлийн хувьд, дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) тухайн эд зүйлийн загварын зөвшөөрөл эзэмшдэг, эсхүл эзэмших хүсэлт гаргасан байх; эсхүл</p> <p>(2) тухайн эд зүйлийн загварын зөвшөөрөл эзэмшдэг, эсхүл эзэмших хүсэлт гаргагчтай Даргын хүлээн зөвшөөрөхүйц зохицуулалт хийсэн байх.</p>	<p>148.53. Маягийн гэрчилгээ ба загварын зөвшөөрөл</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь үйлдвэрлэх агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, эсхүл сэнсний маяг бүрийн хувьд:</p> <p>1/ ИНД-21-ийн “Б” бүлэгт заасан маягийн гэрчилгээтэй, эсхүл</p> <p>2/ ИНД-21-ийн “Д” бүлэгт заасан нэмэлт маягийн гэрчилгээтэй байна.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь агаарын хөлөг, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнснээс бусад, агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн бүрийн хувьд:</p> <p>1/ бүтээгдэхүүнд зориулсан загварын зөвшөөрөлтэй байна; эсхүл</p> <p>2/ загварын зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргаж буй тохиолдолд ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p>	<p>-Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>148.59. Үйлдвэрлэлийн хяналтын журам</p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан үйлдвэрлэлийн ажиллагаанд шаардлагатай үйлдвэрлэлийн процедурын заавар, байгууламжийн заавар, инженерингийн зураг, тодорхойлолт, техникийн стандарт практик ажиллагааны заавар болон бусад баримт бичгийн хувийг хадгалах үүрэгтэй.</p> <p>(b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч</p>	<p>148.59. Үйлдвэрлэл хяналтын журам</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагааны заавартаа заасан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бататгахад шаардагдах заавар, тоног төхөөрөмжийн заавар, инженерингийн зураглал, тодорхойлолтууд, техникийн стандартууд болон бусад бичиг баримтуудын хувийг хадгална.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь дараах журмуудыг боловсруулсан байна:</p>	

нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагад хүргэгдэж ирэх хүртэл бүрэн гүйцэд үзлэг шалгалт хийгдэх боломжгүй эд анги, эсхүл иж бүрдэл нь хүлээн зөвшөөрөхүйц чанартай болохыг бататгах аргыг багтаасан, туслан үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн, эсхүл худалдан авсан бэлдэц материал, эд анги болон иж бүрдлийн үзлэг шалгалт хийх;
- (2) үйлдвэрлэлийн тусгай процесс оролцсон болохыг таньж тодорхойлох тухайн процессыг хянахад ашигладаг арга хэлбэрийг багтаасан, үйлдвэрлэлийн явцад тухайн эд анги болон иж бүрдэлд үзлэг шалгалт хийх;
- (3) хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс туслан гэрээлэгчийн гүйцэтгэх үйлдвэрлэлийн ажиллагааны хувьд, дараах шаардлагыг бататгах:
 - (i) байгууллагын Ерөнхий зааварт тодорхойлсон байх;
 - (ii) байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан тогтолцоо, журам, болон тодорхойлолтыг хангадаг байх;
- (4) хүлээн авахаас татгалзсан материал, эд анги болон иж бүрдлийг устгах болон тухайн шийдвэрийн бүртгэлийг багтаасан, маягийн загвар, эсхүл тодорхойлолттой нийцээгүй материал, эд анги, эсхүл иж бүрдлийг зохицуулах;
- (5) бүрэн үйлдвэрлэсэн эд зүйл болон дараах баримт бичгийг багтаасан төгсгөлийн тест хийх:
 - (i) агаарын хөлгийн хувьд үйлдвэрлэлийн шалгах нислэгийн журам болон шалгах хуудас;
 - (ii) хөдөлгүүрийн хувьд хөдөлгүүрийн test cell-ийн шалгах журам болон шалгах хуудас;
 - (iii) алхмаа удирддаг сэнсний хувьд сэнсний ажиллагааны тест хийх журам;
- (6) бүрэн үйлдвэрлэсэн эд зүйлийг таньж тодорхойлох, үйлчилгээ хийх, хадгалах болон баглах;
- (7) [үйлдвэрлэсэн эд зүйлд CAA Form One-шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ болон нийцлийн мэдэгдэл гаргах;](#)
- (8) CAA Form One-шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ, эсхүл нийцлийн мэдэгдэл гаргах эрх бүхий ажилтны жагсаалтыг хөтлөх;

1/ холбогдох үйлдвэрлэгчийн боловсруулсан, эсхүл уг үйлдвэрлэгчээс худалдан авсан болон угсарсан эд ангиуд, түүхий эд, материалуудыг хүлээн авч шалгах журам;

2/ тодорхой эд анги болон үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн явц (үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тодорхой процесс)-д шалгах журам;

3/ гэрээт байгууллага нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцож байгаа тохиолдолд:

3.1 энэ тухай өргөдөл гаргагчийн зааварт тусгасан байх журам;

3.2 өргөдөл гаргагчийн зааварт заасан систем, журам, онцлог нөхцөл байдалд нийцэж байх журам;

4/ тухайн бүтээгдэхүүний маягийн загвар, тодорхойлолтод нийцээгүй эд анги, материал ба угсарсан эд ангийг ашиглахгүй байх, тэдгээрийг үйлдвэрлэлд ирүүлсэн тохиолдолд ашиглахаас татгалзсан тэмдэглэл буюу бичилт хийх, ангилан зохицуулах зэрэг үйл ажиллагааг агуулсан журам;

5/ бэлэн болсон бүтээгдэхүүний төгсгөлийн сорилтын дараах журмууд:

5.1 агаарын хөлгийн хувьд шалгах нислэгийн журам /шалгах хуудас/;

5.2 хөдөлгүүрийг шалгах журам /шалгах хуудас/;

5.3 удирдлагатай сэнснүүдийн ажиллагааг шалгах журам.

6/ бүтээгдэхүүнийг тэмдэглэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, савлах, баглах журам;

7/ бүтээгдэхүүнийг баталгаажуулсан гэрчилгээ, тодорхойлолт гаргах эрх бүхий ажилтнуудын бүртгэл хөтлөх журам;

8/ энэ зүйлийн (а)-д шаардсан бичиг баримтыг хянах зорилго бүхий:

8.1 бичиг баримтыг гаргахын өмнө эрх бүхий ажилтан хянаж баталгаажуулах журам ;

8.2 өргөдөл гаргагчийн зааварт тусгагдсан үйл

-Орчуулга, найруулга зассан

-Amend.2-оор нэмэгдсэн

<p>(9) дараах шаардлагыг бататгах зорилгоор, энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийг хянах:</p> <ul style="list-style-type: none"> (i) баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх; (ii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан үйлдвэрлэлийн ажиллагааг хэрэгжүүлэхдээ ажилтан хэрэгтэй үедээ ашиглахад боломжтой байх зорилгоор, холбогдох хүчинтэй баримт бичгийг шаардлагатай байрлал бүрд бэлэн байлгах; (iii) хүчингүй болсон баримт бичгийг олгох цэгээс, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс нэн даруй хураадаг байх; (iv) баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх; (v) <u>хугацаа дууссан баримт бичиг ашиглагдаагүй болохыг бататгах зорилгоор баримт бичгийн зүйл бүрийн, хүчинтэй хувилбар нь танигддаг байх;</u> <p>(10) Даргын хүсэлтээр, үйлдвэрлэлийн мэдээлэл, инженерингийн зураг, тестийн тайлан болон үзлэг шалгалт хийсэн бүртгэлийг хүргүүлэх.</p>	<p>ажиллагаанд холбогдох хүчин төгөлдөр бичиг баримтуудыг шаардлагатай ажлын байруудад ашиглах боломжоор ажилтнуудыг хангах журам;</p> <p>8.3 хуучирсан, хүчин төгөлдөр бус бичиг баримтуудыг нэн даруй ашиглалтаас хасах журам;</p> <p>8.4 бичиг баримтад оруулсан нэмэлт өөрчлөлт бүрийг хянаж, баталгаажуулах журам;</p> <p>9/ шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл, инженерингийн зураглал, сорилт шалгалтын тайлан болон үзлэг шалгалтын тэмдэглэлийг ИНЕГ-ын хүсэлтээр ашиглуулах журам.</p>	<p>-Орхигдсон заалтыг нөхөж оруулсан</p>
<p>148.61. Нислэгт тэнцэх чадварын хадгалалт</p> <p>(а) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн байгууллагын үйлдвэрлэсэн эд зүйлийн гэмтэлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, шинжлэн шалгах, дүн шинжилгээ хийх болон тухайн мэдээллийг дараах этгээдэд түгээх:</p> <ul style="list-style-type: none"> (i) тухайн загвартай ижил загвараар үйлдвэрлэсэн эд зүйлийн худалдан авагч бүрд; (ii) холбогдох маягийн гэрчилгээ эзэмшигчид; <p>(2) гэмтлийн зөрчлийн мэдээллийг ИНД-12-т заасны дагуу</p>	<p>148.63. Нислэгт тэнцэх чадварын хадгалалттай <u>холбоотой журам</u></p> <p>(а) Энэ дүрмийн дагуу агаарын хөлөгт хамаарах бүтээгдэхүүн, эд ангийн Загвар зохион бүтээх байгууллага /design organisation/-ын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дараах журмуудыг боловсруулсан байна:</p> <p>1/ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ илэрсэн гэмтэл дутагдлын тухай мэдээллийг цуглуулах, судлах, шинжлэн шалгах журам ба энэ тухай мэдээллийг:</p> <p>1.1 тухайн маягт хамаарах бүтээгдэхүүнийг худалдан авагчдад.</p> <p>1.2 холбогдох маягийн гэрчилгээ эзэмшигчид түгээх журам.</p>	

<p>ИНЕГ-т хүргүүлэх.</p> <p>(b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, үйлдвэрлэж байгаа маягаар гэрчилгээжсэн бүтээгдэхүүнд энэ зүйлийн (a)-д шаардсан журмаас гадна дараах зорилгоор нэмэлт журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1) тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой НТЧ-ын хадгалалтын арга хэмжээ авахад нь бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшигчид дэмжлэг үзүүлэх;</p> <p>(2) ИНД-21-ийн Хавсралт С-д заасан хамааралтай НТЧ-ын загварын стандартын дагуу, бүтээгдэхүүн нийлүүлсэн өдрийн байдлаар бэлтгэсэн НТЧ-ын хадгалалтын зааврын нэгээс доошгүй иж бүрдлээр тухайн бүтээгдэхүүнийг худалдан авагч бүрийг хангах;</p> <p>(3) энэ зүйлийн (b)(2)-т шаардсан НТЧ-ын хадгалалтын зааварчилгааг гаргах ба түүний өөрчлөлтийг, дүрмийн дагуу эдгээр зааварчилгааг мөрдөхийг шаарддаг бусад этгээд ашиглахад бэлэн байлгах;</p> <p>(4) тухайн бүтээгдэхүүнтэй холбоотой гэмтлийн мэдээлэл цуглуулах зорилгоор, энэ зүйлийн (a)-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээллийг ижил маягийн бүтээгдэхүүний өмчлөгч бүрд хүргүүлэх.</p>	<p>2/ гэмтэл дутагдлын тухай мэдээллийг ИНД-12-т заасны дагуу ИНЕГ-т мэдэгдэх журам.</p> <p>(б) ҮБ-ын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь, үйлдвэрлэж буй маягийн гэрчилгээ бүхий бүтээгдэхүүн бүрийн хувьд дараах журмуудыг боловсруулсан байна:</p> <p>1/ үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын хадгалалтын талаар тухайн бүтээгдэхүүний маягийн гэрчилгээ эзэмшигчтэй хамтран ажиллах журам;</p> <p>2/ бүтээгдэхүүн худалдан авагчийг ИНД-21-ийн Хавсралт В-д заасан НТЧ-ын суурь стандартуудын дагуу хийгдсэн, НТЧ-ын хадгалалтыг хангахад чиглэсэн иж бүрэн зааварчилгаар хангах журам;</p> <p>3/ энэ хэсгийн 2/-т заасан зааварчилгуудыг боловсруулах, зааварчилгууд болон тэдгээрт хийгдсэн өөрчлөлтүүдийг холбогдох этгээдэд хүргэх журам;</p> <p>4/ энэ зүйлийн (a)-д заасан журмуудын талаар ижил маягийн бүтээгдэхүүн эзэмшигчдэд мэдээлэх журам.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>148.63. Бүртгэл <u>хөтлөх</u></p> <p>(a) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, үйлдвэрлэсэн эд зүйл нь холбогдох загварын өгөгдөл болон аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд тохирч байгааг бататгахад шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах <u>журмыг тогтоох үүрэгтэй.</u></p> <p>(b) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтоох үүрэгтэй:</p> <p>(1) гэрчилгээ эзэмшигчийн нэрийн өмнөөс гэрчилгээжүүлэлтийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдийн туршлага, мэргэшил, сургалт болон эзэмшиж байгаа хүчинтэй эрхийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх;</p> <p>(2) гэрчилгээ эзэмшигчийн үйлдвэрлэсэн эд зүйл бүрд, гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг багтаасан бүртгэл хөтлөх;</p> <p>(3) эд зүйл нь холбогдох загварын өгөгдөлд тохирч байгаа болон аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд байгааг гэрчилгээжүүлсэн этгээд болон огноог бүртгэх;</p> <p>(4) тохируулга хийхэд ашигласан стандартыг багтаасан,</p>	<p>148.67. Бүртгэл, <u>тэмдэглэлд тавигдах шаардлага</u></p> <p>(a) Өргөдөл гаргагч нь, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн бүр нь холбогдох загварын өгөгдөхүүнүүдэд нийцэж буйг, мөн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангаж буйг баталгаажуулахад шаардлагатай бүртгэл, тэмдэглэл хөтлөх, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, ашиглах, устгах <u>журмыг боловсруулна.</u></p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах зүйлүүдийг багтаасан журмыг боловсруулсан байна:</p> <p>1/ бүтээгдэхүүнийг ашиглалтад гаргах эрх бүхий ажилтны мэргэшил, дадлага туршлага, хамрагдсан сургалтын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх журам;</p> <p>2/ гүйцэтгэсэн ажлын тухай мэдээллийг багтаасан, гэрчилгээ эзэмшигчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний бүртгэл хөтлөх журам;</p> <p>3/ бүтээгдэхүүн нь холбогдох загварын өгөгдөхүүнүүдэд нийцэж буйг болон аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангаж байгааг баталгаажуулсан этгээд болон сар, өдрийг бүртгэх журам;</p> <p>4/ <u>148.57-т</u> заасан бүх материал, багаж, тоног төхөөрөмжүүдийн шалгалт тохируулгын бүртгэл,</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-SMS-ийн шаардлагаар “shall” нь “must” болсон.</p>

<p><u>148.55-д</u> шаардсан төхөөрөмж, багаж хэрэгслийн тохируулгын бүртгэл хөтлөх;</p> <p>(5) дараах шаардлагыг бататгах:</p> <p>(i) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын арилдаггүй байх;</p> <p>(ii) энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (b)(1)-ээс (b)(4)-т заасан бүртгэлийг тухайн эд зүйлийн маягийн сүүлчийн хувилбар ашиглалтаас бүрмөсөн хасагдсанаас хойш 2 жил хадгалдаг байх.</p> <p>(6) <u>Даргын</u> хүсэлтээр энэ зүйлийн (b)(1) (b)(4)-т заасан бүртгэлийг хүргүүлэх.</p> <p>(с) Дарга, бүртгэлийг энэ зүйлийн (b)(5)(ii)-т шаардсанаас богино хугацаагаар хадгалахыг зөвшөөрч болно.</p>	<p>тэмдэглэлийн журам;</p> <p>5/ энэ хэсгийн 1/-ээс 4/-т заасан бүртгэл, тэмдэглэл дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>5.1 бүх бүртгэл тодорхой, гаргацтай, тогтсон загвартай байна;</p> <p>5.2 энэ хэсгийн (в)-д зааснаас бусад тохиолдолд, тэмдэглэлүүдийг тухайн маягийн бүтээгдэхүүн ашиглалтаас хасагдсанаас хойш 2 жил хадгална.</p> <p>6/ <u>ИНЕГ-аас</u> шаардсан тохиолдолд, энэ хэсгийн 1/-4/-т заасан мэдээллийг ИНЕГ-т хүргүүлэх журам.</p> <p>(в) Бүртгэл, тэмдэглэлийг энэ хэсгийн (б)-гийн 5/-ийн 5.2-т зааснаас бага хугацаагаар хадгалах тухай хүсэлтийг ИНЕГ-т гаргаж болно.</p>	
<p>148.65. Аюулгүй байдлын удирдлага</p> <p>Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.</p>	<p>148.69. Чанарын дотоод баталгаажуулалтын систем</p> <p>(а) Өргөдөл гаргагч нь, энэ дүрмээр шаардсан журмууд хэрхэн мөрдөгдөж байгаа, үйл ажиллагаанд хэрхэн нийцэж байгааг бататгах зорилго бүхий чанарын дотоод баталгаажуулалтын системтэй байна.</p> <p>(б) Чанарын дотоод баталгаажуулалтын систем нь дараах журмуудад үндэслэнэ:</p> <p>1/ Аюулгүй ажиллагааны журам- эдгээр журмууд нь ойлгомжтой, байгууллагын бүх түвшинд хэрэгжихүйц байна/;</p> <p>2/ Осол, дутагдлын бодит шалтгааныг тодорхойлох, шинжилгээ хийх журам- энэ журамд дараах зүйлүүд тусгагдсан байна:</p> <p>2.1 дутагдлыг хэрхэн арилгах талаар;</p> <p>2.2 дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд холбогдох журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;</p> <p>2.3 дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд үндэслэн удирдлага зохион байгуулалтын системээ хянах талаар.</p> <p>3/ Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам- энэ журамд дараах зүйлүүд тусгагдсан байна:</p> <p>3.1 үүсэж болзошгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар;</p> <p>3.2 урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд холбогдох журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;</p> <p>3.3 урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн удирдлага зохион байгуулалтын системээ хянах талаар.</p> <p>4/ Аудитын дотоод хөтөлбөр- энэ хөтөлбөрт дараах зүйлүүд тусгагдсан байна:</p> <p>4.1 аудит хийгдэх объект, давтамж;</p>	<p>-D Бүлэг-Шилжилтийн зохицуулалтаар илүү тодорхой болж орсон.</p>

	<p>4.2 аудитыг хэн гүйцэтгэх; 4.3 шалгалтын дүнг хэрхэн мэдээлэх ; 4.4 шалгалтаар дутагдал илэрвэл түүнийг арилгах арга хэмжээний талаар; 4.5 дутагдлыг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх, шалгалтын мөрөөр хийгдсэн ажлын үр дүнг хэрхэн хянах талаар.</p> <p>5/ Удирдлага зохион байгуулалтын хяналтын журам- энэ журамд: 5.1 чанар баталгаажуулалтын системийн идэвхтэй ажиллагааг хангах үүднээс тухайн системийн удирдлага зохион байгуулалтад хяналт тавих үечлэлийг заасан байна; 5.2 чанар баталгаажуулалтын системд хяналт тавих эрх бүхий этгээдийг тодорхойлсон байна.</p> <p>(в) Чанарын дотоод баталгаажуулалт хариуцсан этгээд нь аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар ҮБ-ын удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй байна.</p>	
<p>148.67. <u>Үйлдвэрлэх байгууллагын Ерөнхий заавар</u></p> <p>(а) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй: (1) <u>Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журам дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:</u> (i) <u>тухайн үйлдвэрлэх байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;</u> (ii) <u>түүнийг ажилтан байнга дагаж мөрдөх;</u> (1A) <u>148.65-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:</u> (i) <u>ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;</u> (ii) <u>үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;</u> (2) 148.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр; (3) 148.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан,</p>	<p>148.71. <u>Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт тавигдах шаардлага</u></p> <p>(а) <u>Өргөдөл гаргагчийн</u> Үйл ажиллагааны заавар нь энэ дүрмийн шаардлагуудад бүрэн нийцсэн байхын зэрэгцээ дараах зүйлүүдийг тусгасан байна: <u>1/ 148.51-ын (а)-ийн 1/ ба 2/-т заасан удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын албан тушаал, нэрс;</u></p> <p>2/ удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын хүлээх үүрэг, хариуцлага; 3/ удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын хүлээх</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан.</p> <p>-SMS-ийн шаардлагатай холбоотой нэмэлтээр орсон</p>

эсхүл удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагыг багтаасан:

- (i) байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
- (ii) аюулгүй байдлын удирдлагын хариуцлага;

(4) 148.51(а)(1) болон (2)-т заасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(4A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;

(5) хүсэлт гаргагчийн байгууллагын үйлдвэрлэлийн ажиллагаа гүйцэтгэх бүх байрлал, тэдгээр байрлалд байгаа байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6) энэ зүйлийн (а)(5)-ын дагуу дэлгэрэнгүй заахыг шаардсан, байрлал бүрд байгаа хүсэлт гаргагчийн байгууллагын ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(7) хүсэлт гаргагчийн байгууллагын гүйцэтгэх ажлын цар хүрээний дэлгэрэнгүй тодорхойлолт;

(8) дараах дүрэмд шаардсан байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл:

(i) 148.53(b)(3) - эд ангийг хадгалах болон ангилан тусгаарлах шаардлага хангасан байгууламжийн хангалт;

(ii) 148.53(b)(4) хүрээлэн бүй орчны нөхцөлийн хангалт;

(9) гадны туслан гэрээлэгч, эсхүл ханган нийлүүлэгчийн үйлдвэрлэсэн, эсхүл нийлүүлсэн чухал эд ангийн жагсаалт;

(10) хүсэлт гаргагчийн байгууллага нь 148.57-д шаардсан маягийн гэрчилгээ, эсхүл нэмэлт маягийн гэрчилгээ эзэмшдэг, эсхүл эдгээрийг эзэмших хүсэлт гаргасан, эсхүл зохицуулалтад орсныг нотлох баримт;

(11) хүсэлт гаргагчийн байгууллагаас салбар байгууллагад олгосон аливаа эрхийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(12) дараах дүрэмд шаардсан, хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл:

(i) 148.51(b) - ажилтны ур чадварын үнэлгээний талаар;

(ii) 148.51(b) - ажилтны ур чадварын хадгалалтын талаар;

(iii) 148.55(2) - багаж, эталон, боловсруулалтын төхөөрөмж (process equipment) болон тестийн төхөөрөмжийн (test equipment) хяналт,

үүрэг хариуцлагыг үзүүлсэн байгууллагын бүтцийн зураглал;

4/ энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, техник үйлчилгээ, засварын ажил гүйцэтгэх байршил болон тухайн байршил дахь байгууламж, тоног төхөөрөмжийг нарийн тодорхойлж, байршил бүрийн бүтэц зохион байгуулалтын зураглал;

5/ гүйцэтгэх үйл ажиллагаа, ажлын багтаамжийг нарийвчлан тодорхойлсон байна;

6/ дараах шаардлагуудыг дэлгэрэнгүй тусгасан журмууд:

6.1 148.51-ын (б)-д тусгагдсан ажилтнуудын ур чадварын талаар;

6.2 148.51-ын (б)-д тусгагдсан ажилтнуудын сургалтын талаар;

6.3 148.55-ийн (а)-гийн 3/-т тусгагдсан эд ангийг

-Орчуулга, найруулга зассан

-SMS-ийн шаардлагатай холбоотой нэмэлт

-Amend. 4-өөр нэмэлтээр орсон

-6-р заалт нь 12-р заалт болж өөрчлөгдсөн

тохируулгын талаар;

- (iv) 148.59(b)(1) - бэлдэц материал, эд анги, тоноглолын үзлэг шалгалтын талаар;
- (v) 148.59(b)(2) - үйлдвэрлэлийн явц дахь эд ангийн болон иж бүрдлийн үзлэг шалгалтын талаар;
- (vi) 148.59(b)(3) - үйлдвэрлэлийн ажиллагааг туслан гэрээлэх талаар;
- (vii) 148.59(b)(4) - үл тохирох материал болон эд ангийн талаар;
- (viii) 148.59(b)(5) - төгсгөлийн тестийн талаар, хэрэв хамааралтай бол, ИНД-21.197-гийн дагуу олгосон байнгын зөвшөөрөлтэй тусгай нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргахад шаардлагатай журмыг багтаасан;
- (ix) 148.59(b)(6) - үйлдвэрлэж байгаа эд зүйлийг таньж тогтоох, үйлчилгээ хийх, хадгалах болон баглах талаар;
- (x) 148.59(b)(7) - болон (8) - CAA Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ болон нийцлийн мэдэгдэл гаргах талаар;
- (xi) 148.59(b)(9) - баримт бичгийг хянах болон түгээх талаар;
- (xii) 148.61(b) - үйлдвэрлэж байгаа эд зүйлийн НТЧ-ын хадгалалтын талаар;
- (xiii) 148.63 - бүртгэлийг таньж тогтоох, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах талаар;

(13) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

хадгалах нөхцөлийг хангах талаар;

- 6.4 148.55-ийн (б)–д тусгагдсан орчны нөхцөлийг хангах талаар;
- 6.5 148.57-ын 2/–т тусгагдсан шалгах тоног төхөөрөмж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн шалгалт тохируулга болон хяналтын талаар;
- 6.6 148.59-ийн (б)–гийн 1/-д тусгагдсан түүхий эд, эд анги, агрегатад үзлэг хийх талаар;
- 6.7 148.59-ийн (б)–гийн 2/-т тусгагдсан үйлдвэрлэлийн явцад эд анги, угсарсан эд ангид хийх үзлэг шалгалтын талаар;
- 6.8 148.59-ийн (б)–гийн 3/-т тусгагдсан гэрээт үйл ажиллагааны талаар;
- 6.9 148.59-ийн (б)–гийн 4/-т тусгагдсан үл тохирох материал, эд ангид хамаарах журмын талаар;
- 6.10 148.59-ийн (б)–гийн 5/-д тусгагдсан бүтээгдэхүүний төгсгөлийн тест, шалгалтын талаар;
- 6.11 148.59-ийн (б)–гийн 6/-д тусгагдсан сэлбэг материалыг боож баглах, савлах, зөөх, хадгалах, илгээх, хүлээн авах, шалгах, хаяглах талаар;
- 6.12 148.59-ийн (б)–гийн 7/-д тусгагдсан бүтээгдэхүүнийг баталгаажуулсан бичиг баримтын талаар;
- 6.13 148.59-ийн (б)–гийн 8/-д тусгагдсан бичиг баримтын ашиглалт, хөтлөлт, түгээлтийн талаар;
- 6.14 148.63-д тусгагдсан үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний НТЧ-ын хадгалалтын талаар;
- 6.15 148.67-д тусгагдсан бүртгэл, тэмдэглэлийг боловсруулах, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, ашиглах, устгах талаар;
- 6.16 148.69–д тусгагдсан байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтын системийн талаар;

7/ Үйл ажиллагааны зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт хийх, түгээх журмууд.

(б) Үйл ажиллагааны заавар нь ИНЕГ-аар хүлээн зөвшөөрөгдөөгүй бол өргөдөл гаргагчид үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ олгохгүй.

С Бүлэг-Үйл ажиллагааны шаардлага	БҮЛЭГ В. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГУУД	
<p>148.101. <u>Байнгын хэрэгжилт</u> Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь:</p> <ol style="list-style-type: none"> (1) байгууллагын Ерөнхий зааврын хүчинтэй нэгээс доошгүй бүрэн хувийг Ерөнхий зааварт заасан ажлын байрлал бүрд хадгална; (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог дагаж мөрдөнө; (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажилтанд хэрэглэх боломжтой байлгана; (4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэхэд тавих В Бүлгийн шаардлагыг хэрэгжүүлэн, стандартыг байнга дагаж мөрдөнө; (5) үйлдвэрлэлээс гарсан эд зүйл нь холбогдох загварын өгөгдөлд нийцэж <u>байгаа</u>, аюултай хэв шинжгүй болон аюулгүй ажиллагааг хангах нөхцөлд байгааг тодорхойлно. 	<p>148.101. <u>Тогтмол хэрэгжилт</u> (а) Гэрчилгээ эзэмшигч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1/ үйл ажиллагааны зааврынхаа хувийг зааварт заасан ажлын байр бүрт хадгалж, ашиглана; 2/ зааварт тусгагдсан бүх журмуудыг мөрдөнө; 3/ ажилтнууд нь, албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах зааврын тодорхой хэсгүүдээр хангагдсан байна; 4/ ҮБ нь энэ дүрмийн “Б” бүлгийн шаардлага, стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулна; 5/ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь холбогдох загварын өгөгдөхүүн, стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна. 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>148.103. <u>Үйлдвэрлэгдсэн эд зүйлийг таньж тодорхойлох</u> Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь тухайн үйлдвэрлэх байгууллагын үйлдвэрлэсэн эд зүйлд ИНД-21-ийн Q Бүлгийн шаардлагын дагуу <u>таних тэмдэглэгээ хийх үүрэгтэй.</u></p>	<p>148.103. <u>Бүтээгдэхүүний тэмдэг</u> (а) ҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн, ИНД-21-ийн Н Бүлэгт заасны дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн бүр нь үйлдвэрлэлийн <u>тэмдэгтэй байна.</u></p>	<p>-SMS-тэй холбоотойгоор “shall” нь “must” болсон.</p>
<p>148.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт</p> <p>(а) Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь, 148.67-д шаардсан Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг, тухайн байгууллагын хүчинтэй тодорхойлолт хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах үүрэгтэй.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) Ерөнхий зааварт хийсэн нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах; (2) Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөх. <p>(с) Энэ зүйлийн (d)-г харгалзан, гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт <u>оруулсан даруйд</u> нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээс өмнө <u>Даргын</u> зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:</p> <ol style="list-style-type: none"> (1) <u>Гүйцэтгэх захирал</u>; (2) нэр заагдсан удирдах ажилтнууд; (3) <u>үйлдвэрлэлийн зэрэглэл</u>; (4) <u>чухал эд ангиудын ханган нийлүүлэлтийн</u> 	<p>148.105. Гэрчилгээ эзэмшигч байгууллагад <u>орох</u> өөрчлөлт</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны заавартаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа байгууллагын үндсэн чиг үүрэг, тодорхойлолт хэвээр үлдэнэ гэдгийг бататгана.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт орсон бүх нэмэлт, өөрчлөлт нь:</p> <ol style="list-style-type: none"> 1/ энэ дүрмийн шаардлагад нийцсэн байна; 2/ үйл ажиллагааны зааварт тусгагдсан журмын дагуу хийгдсэн байна. <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны заавартаа оруулах нэмэлт өөрчлөлтийг ИНЕГ-аар баталгаажуулна.</p> <p>(г) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлд ИНЕГ-ын саналыг авсны үндсэн дээр өөрчлөлт хийнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1/ <u>удирдах албан тушаалтныг</u> өөрчлөх; 2/ нэр заагдсан удирдах ажилтнуудыг өөрчлөх; 3/ үйлдвэрлэлийн гүйцэтгэх ажилтнуудыг өөрчлөх; 4/ үйлдвэрлэлийн байршил өөрчлөгдөх; 	<p>-Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт “оруулсны дараа” Даргад мэдэгддэг байхаар шаардсаныг “оруулах” гэж ирээдүй цагаар орчуулснаар “бүх өөрчлөлт”-ийг</p>

<p><u>зохицуулалт</u>;</p> <p>(5) тухайн зэрэгэлэлд хамрах хүрээг өөрчлөх журам;</p> <p>(6) байнгын зөвшөөрөлтэй тусгай нислэгийн зөвшөөрөл ашигладаг эзэмшигчийн төгсгөлийн тестийн ажиллагаа;</p> <p>(7) үйлдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа байрлал;</p> <p>(8) <u>аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол.</u></p> <p>(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг <u>Дарга</u> тогтоож болно.</p> <p>(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу <u>Даргын</u> тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр <u>Даргад</u> нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(h) <u>Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.</u></p>	<p>5/ бүтээгдэхүүний төгсгөлийн шалгалт, тестэд өөрчлөлт оруулах.</p> <p>(д) Энэ зүйлийн (г)-д заагдсан өөрчлөлтийн аль нэгийг хийж байх хугацаанд гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг <u>ИНЕГ</u>-аас тодорхойлж өгч болно.</p> <p>(e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (д)-д заагдсан аливаа нөхцөлийг дагаж мөрдөнө.</p> <p>(ж) Энэ зүйлийн (г)-д тусгагдсан өөрчлөлтийн улмаас гэрчилгээнд өөрчлөлт оруулахаар бол эзэмшигч нь гэрчилгээг <u>ИНЕГ</u>-т нэн даруй ирүүлнэ.</p> <p>(з) Гэрчилгээ эзэмшигч нь, <u>ИНЕГ</u>-аас нисэхийн аюулгүй ажиллагааг хангах талаар гаргасан бичиг баримтыг үндэслэн үйл ажиллагааны заавартаа нэмэлт өөрчлөлт оруулна.</p>	<p>Даргад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсны дараа хийх болгож өөрчилсөн байна.</p> <p>-SMS-тэй холбоотой нэмэгдсэн</p> <p>-Amend.2-оор өөрчлөгдсөн</p>
<p>D Бүлэг-Шилжилтийн зохицуулалт</p>		<p>-Шинээр нэмэгдсэн</p>
<p>148.151. Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилт</p> <p>(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:</p> <p>(1) үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч;</p> <p>(2) үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.</p> <p>(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:</p> <p>(1) 148.51(a)(2)(iv)-ийг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;</p> <p>(2) 148.65-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 148.153-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;</p> <p>(3) 148.67(a)(1A)(i)-ийг;</p> <p>(4) 148.67(a)(3)(ii)-ыг;</p> <p>(5) 148.67(a)(4A)-г.</p>		<p>-Amend.5-аар нэмэгдсэн</p>

- (с) Гүйцэд бөглөсөн ИНЕГ маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (а)(2)-ын дагуу үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас хойш;
 - (2) энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас өмнө.
- (d) Энэ зүйлийн (с)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:
- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;
 - (2) тухайн байгууллага 148.65-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.
- (e) Дарга, хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол:
- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
 - (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн огноог тогтооно.
- (f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:
- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
 - (2) тухайн байгууллагын төвөгшил;
 - (3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
 - (4) гэрчилгээ сунгах хугацаа;
 - (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
 - (6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.

148.153. Үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт

(a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 148.151(b)(1)(ii)-г шаардсан дотоод чанар

-Amend.4-өөр
нэмэгдсэн

баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаах ёстой:

- (1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилт болон үйлчлүүлэгчийн хүсэл хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;
- (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;
- (3) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг залруулсан болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;
- (4) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
- (5) хүсэлт гаргагчийн байгууллагын аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх зорилгоор аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
- (6) энэ Дүрмийн шаардлагыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохиромжтой болон үр дүнтэй байдлыг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам.

(c) Аюулгүй байдлын бодлогын журам нь аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгож хэрэгжүүлж, мөрдөж байгааг бататгах ёстой.

(d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:

- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах залруулах арга хэмжээг эргэн хянах;
- (3) залруулах арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
- (4) авсан залруулах арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.

(e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:

- (1) Хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;
- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн хянах;

(3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

(4) авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.

(f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь:

(1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцож аудит хийх байрлал болон давтамжийг тодорхойлох;

(2) аудитыг тухайн үйл ажиллагаанд шүүд хариуцлага хүлээдэггүй, сургалтад хамрагдсан аудитын ажилтнаар гүйцэтгэдэг болохыг бататгах;

(3) аудитын үр дүнг аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгах;

(4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;

(5) авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнд үнэлгээ хийх зорилгоор эргэн хянах аудит хийдэг болохыг бататгах ёстой.

(g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь:

(1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг үндэслэн чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлох;

(2) чанар баталгаажуулалтын тогтолцооны дүгнэлт хийх хариуцлага хүлээсэн менежерийг тодорхойлох;

(3) дүгнэлтийн үр дүнг дүгнэж бүртгэл хийдэг болохыг бататгах ёстой.

(h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралтай шүүд харьцах эрхтэй.

(i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.

Дүрмийн боловсруулалтын хэлтэс